

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ. БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ОРОН ЗАЙН
ӨГӨГДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

MNS : 2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР
2021 ОН

ӨМНӨХ ҮГ

Стандарт, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.

Энэхүү стандартыг Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Баяртунгалаг, А.Түрүүтүвшин, мэргэшсэн инженер Ц.Наранцацрал, доктор Б.Сайнбуян, З.Нямбаяр, мэргэшсэн инженер А.Алтанбагана нар хамтран гүйцэтгэв.

Шинжлэх ухаан технологийн сургуулийн Геологи уул уурхайн сургуулийн ахлах багш МУ-ын мэргэшсэн инженер Б.Болормаа редакц хийж, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн багш, доктор, профессор Ч.Оюунжаргал шүүмжийг хийв.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Энэ стандартын төслийг ТХ-36/Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Уг стандартыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ийн дагуу хянаж, боловсруулав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар хот 13348 ШХ-48

Утас: (976-51) 263860

Факс: (976-11) 458032

Цахим шуудан: standardinform@masm.gov.mn

Цахим хуудас: www.estandart.gov.mn,

www.masm.gov.mn

СХЗГ 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын Төв байгууллага) -т байна.

АГУУЛГА

ОРШИЛ.....	1
1 Хамрах хүрээ	2
2 Норматив эшлэл.....	2
3 Нэр томъёо, тодорхойлолт.....	3
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт	3
3.2 Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт	4
4 Техникийн шаардлага	5
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага	6
4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага.....	8
4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага.....	9
4.4 UML диаграмм (норматив).....	9
4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага.....	9
4.6 Өгөгдлийн элементүүдийн тайлбар зураг (мэдээллийн).....	10
A Хавсралт – Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга	11
B Хавсралт – Кодын жагсаалт	75
C Хавсралт – UML диаграмм	106
D Хавсралт – Өгөгдлийн чанар.....	112
E Хавсралт (мэдээллийн) – Өгөгдлийн элементүүдийн тайлбар зураг	112

ОРШИЛ

Энэхүү стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгоно.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Стандартын техникийн шаардлагуудыг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт, олон улсын стандартын байгууллага (ISO)-ын TX 211 (ISO/TC 211-Geographic information/Geomatics) -с гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлагад тулгуурлаж, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон боловсруулав.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлэн боловсруулав.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Уг стандарт нь барилга байгууламжийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Барилга байгууламжийн орон зайн суурь өгөгдөлд бодит биет байдлаар орших барилга, байгууламж, түүний бүрэлдэхүүн хэсэг болох суурилуулсан биетүүд, хана, шал, дээвэр, хаалга, цонхны хоёр болон гурван хэмжээст өгөгдлүүдээс гадна, тухайн барилгатай холбоотой геометр дүрслэл агуулаагүй хийсвэр байдлаар бүрдүүлсэн шинж чанарын мэдээллийг агуулна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Барилга байгууламжийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS ... 2021
Geographic information. Data specification on Building Construction	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны дугаар сарынний өдрийн дугаар тушаалаар батлав

Энэхүү стандарт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.

Стандартын шаардлага нь заавал мөрдөгдөнө.

1 Хамрах хүрээ

Барилга байгууламжийн орон зайн суурь өгөгдлийн сан нь Монгол орны барилгын элементүүд (барилга болон барилгын хэсгийн биет төрлүүд) болох барилга, барилгын хэсэг, барилгын нэгж, давхар, барилгын өрөө, суурилуулалт, хана, дээвэр, хаалга, цонх болон бусад байгууламж түүний дагалдах бүх элементүүд, тэдгээрийн мэдээллийг агуулахад хамаарна.

Энэхүү стандарт нь барилга, байгууламжийн орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд барилга, байгууламжийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO/TS 19103:2005, Газар зүйн мэдээлэл – Ойлголтын схемийн хэл;

ISO 19107: 2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;

ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;

ISO 19108-с, 2002/Cor 1: 2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;

ISO 19109:2005, Газар зүйн мэдээлэл – Хэрэглээний схемийн дүрмүүд;

ISO 19111: 2007, Газар зүйн мэдээлэл – Орон зайн суурь солбицол;

ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;

ISO 19123: 2007, Газар зүйн мэдээлэл – Багц давхаргын геометр ба функцийн схем;

ISO/TS 19127:2005, Газар зүйн мэдээлэл – Геодезийн код ба параметрууд;

ISO 19131:2007, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн бүтээгдэхүүний тодорхойлолт;
ISO 19138: 2006, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;
ISO/DIS 19156, Газар зүйн мэдээлэл – Ажиглалт ба хэмжилт;
ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;
MNS ISO/TS 19104:2012 Газарзүйн мэдээлэл - Нэр томьёо

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

Үндсэн агуулгад хамаарах ойлголт

3.1.1

орон зайн өгөгдөл

газрын гадарга дээрх болон доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц

3.1.2

орон зайн суурь өгөгдөл

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл

3.1.3

өгөгдлийн багц

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулга

3.1.4

стерео төрөл

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрлийг

3.1.5

өгөгдөл төрөл

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрлийг

3.1.6

биет төрөл

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрслэгдсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрөл.

3.1.7

мета өгөгдөл

орон зайн өгөгдлийг хайх, бүртгэх, ашиглахад зориулагдсан орон зайн өгөгдлийн тухай мэдээллийн цогц (өгөгдлийн тухай өгөгдөл).

3.1.8

кодын жагсаалт

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутадад ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

3.1.9

домэйн

тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлэгч. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” л байх ёстой гэсэн шалгуур нь домэйн болохыг.

3.2

Атрибутын утгын төрөлд /Value type/ хамаарах ойлголт

3.2.1

Boolean

тухайн мэдээлэл үнэн эсвэл худлаа гэсэн хоёр боломжит утгын аль нэгийг сонгоход хэрэглэдэг утгын төрөл юм (ихэвчлэн тийм бөгөөд үгүй гэсэн төрөл ашигладаг). [эх сурвалж: ISO/TS 19103:2005]

3.2.2

Character string

тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт. [Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005]

3.2.3

DateTime

цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна. [Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005]

3.2.4

Decimal

аравтын бутархайгаар илэрхийлэгдсэн бутархай тоон утга.

3.2.5

GM_MultiCurve

нэгэн зэрэг 2 болон түүнээс дээш тасралтгүй холбогдсон, муруй хэлбэрийн шугаман дүрслэл.

3.2.6

GM_MultiSurface

олон гадаргуу бүхий геометр биет. [Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005]

3.2.7

GM_MultiSolid

нэг буюу нийлмэл хатуу биет гадаргуугийн 2 хэмжээст өгөгдөл нь геометрийн 3 хэмжээст дүрслэлийн үндэс суурь болж өгнө.

3.2.8

GM_Object

геометрийн объектын ангилал зүйн язгуур анги бөгөөд газарзүйн хувьд хамааралтай бүх геометрийн объектуудыг төлөөлдөг.

3.2.9

GM_Primitive

биетийн үндсэн хийсвэр дүрслэл.

3.2.11

GM_Solid

хатуу биетийн гадаргуу. 3 хэмжээст геометрийн үндэс суурь болдог.

3.2.12

Integer

тоон мэдээллийн хуваагдаагүй, задгай нэгж ашиглаагүй бүхэл утга байна. [эх сурвалж: ISO/TS 19103:2005]

3.2.13

Measure

хэмжилтийн үр дүнд гаргасан хэмжигдэхүүний тоон утга. [эх сурвалж: ISO/TS 19103:2005]

3.2.15

Number

тоолсон хэмжсэн үр дүнг илэрхийлдэг тоон төрлийн утга. Энэ нь ерөнхий төрөл бөгөөд тодорхой (exact), болон ойролцоо (approximate) гэж ангилагдана. [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

3.2.16

Real

бодит тооны ойролцоо утгыг илэрхийлэх зорилгоор компьютерын програмд ашигладаг өгөгдлийн төрлийг хэлнэ.

3.2.18

URL


тухайн биетийн бичвэрийн тэмдэгтээр илэрхийлсэн холбоосны утга. [Эх сурвалж: ISO 19136:2007]

4 Техникийн шаардлага

4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох “өгөгдлийн багц”, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй “атрибут”, атрибутад орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан “кодын жагсаалт” гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй (1-р зурагт тоймлон үзүүлэв) байхыг шаардана.

ТӨССӨЛ



1-р зураг – Барилга байгууламжийн орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 А хавсралтаар орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утгад ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

4.1.4 Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «кодын жагсаалт» гэсэн стерео төрөлтэй байх норматив шаардлагыг хангана.

4.1.5 Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

4.1.6 Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

4.1.7 Барилга байгууламжийн орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хүснэгтийн дагуу **барилгын суурь өгөгдөл, хоёр хэмжээст барилга, гурван хэмжээст барилга** гэсэн 3 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

4.1.8 Барилга байгууламжийн орон зайн өгөгдлийн санд 32 биет төрөл, 19 өгөгдөл төрөл агуулна.

4.2 Атрибутаг тавигдах (норматив) шаардлага

4.2.1 Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн норматив шаардлагыг хангана.

4.2.2 Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

4.2.3 Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /ExternalID/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /localID/, “нэрийн талбар” /namespace/, “танигчийн хувилбар” /versionID/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005].

4.2.3.1 “Дотоод танигч /localID/” нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байхыг шаардана.

4.2.3.2 “Нэрийн талбар /namespace/” нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4.2.3.3 “Танигчийн хувилбар /versionID/” нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэсэн байхыг шаардана.

4.2.4 Барилга байгууламжийн орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1 - 4.2.4.2 –д заасан “Газар зүйн нэр” /Geographical Name/, “Хаяг” /Address/ дэд өгөгдлийн сантай холбогдоно.

4.2.4.1 “Газар зүйн нэр” /Geographical Name/ нь тухайн барилга байгууламжийн “Нэр” /name/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Газарзүйн нэр» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газарзүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлт MNS:2021” стандартаас авч ашиглана.

4.2.4.2 “Хаяг” /Address/ нь тухайн барилга байгууламжийн “Хаяг” /Address/ гэх атрибутаар холбогдох бөгөөд утгын төрөл дээр «Хаягийн дүрслэл» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газарзүйн мэдээлэл. Хаягийн өгөгдлийн үзүүлэлт MNS:2021” стандартаас авч ашиглана.

4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага

4.3.1 А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын ангиллын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

4.3.2 Барилга байгууламжийн орон зайн өгөгдлийн санд 34 кодын жагсаалтын агуулна.

4.3.3 А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утгад заасан кодын жагсаалтын дагуу ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

4.4 UML диаграмм (норматив)

4.4.1 Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML - Unified Modeling Language)-ын дагуу өгөгдлийг загварчилна.

4.4.2 Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

4.4.3 С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна барилга байгууламжийн орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага

4.5.1 Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь барилга байгууламжийн суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.4-р хүснэгтэд үзүүлснээр

дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

4.5.2 Барилга байгууламжийн суурь орон зайн өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана.

4.5.2.1 Бүрэн бүтэн байдал өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлт нь өгөгдлийн багц, орон зайн объектын төрлийн түвшинд илүү эсвэл дутуугүй байх шаардлагатай.

4.5.2.2 Байрлалын нарийвчлал өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлт нь өгөгдлийн багц, орон зайн объект, орон зайн объектын төрлийн түвшинд зөвшөөрөгдсөн хэмжээнд алдаатай байх

4.5.2.3 Сэдэвчилсэн нарийвчлал өгөгдлийн багц, биет төрөл, өгөгдөл төрөл, эдгээрийн атрибут нь үнэн зөв бөгөөд сэдэв агуулгын дагуу байх.

4.5.2.4 Хэрэглэхэд тохиромжтой байдал өгөгдлийн багцын тусгайлсан шалгуур үзүүлэлтүүдийг дагаж мөрдөх.

4.6 Өгөгдлийн элементүүдийн тайлбар зураг (мэдээллийн)

4.6.1 Өгөгдөл бүрдүүлэхдээ агуулгын төрөл ангиллыг ялгах, танихад ашиглах жишээ болгон үзүүлсэн тайлбар зургуудыг E хавсралтаас ашиглах боломжтой.

ТӨГСӨВ

А Хавсралт
(норматив)

Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

А. 1-р хүснэгт – Барилга, байгууламжийн орон зайн суурь өгөгдлийн багц ба ангилал

А.1.1 Өгөгдлийн багц: Барилгын суурь өгөгдөл (Buildings base)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Абстракт барилга байгууламж <i>/Abstract construction/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилга, барилгын хэсэг болон байгууламжийн талаарх үндсэн, шинж чанарын мэдээллийг бүртгэх абстракт орон зайн биет төрөл.
2	Абстракт барилга <i>/Abstract building/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Орон зайн биет төрлүүд болох барилга, барилгын хэсэг <i>/Building, Building part/-</i> ийн үндсэн, шинж чанарын мэдээллийг бүртгэх абстракт орон зайн биет төрөл.
3	Барилга <i>/Building/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун, полигон	Барилга гэдэг нь хүн, амьтан амьдрах болон эд зүйл байрлуулах, эсвэл үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэргээр ашиглах зориулалттай газар дээрх болон газар доорх битүү байгууламж юм.
4	Давхрын хязгаар <i>/Floor range/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Давхрын хязгаарыг хамгийн доод ба хамгийн дээд давхраар нь тодорхойлох.
5	Барилгын хэсэг <i>/Building part/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын нэмэлт хэсэг.

6	Барилга ба барилгын нэгжийн мэдээлэл /Building and building unit info/	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилга, барилгын хэсэг, барилгын нэгжийн нэмэлт шинж чанарыг бүртгэх абстракт орон зайн объектын төрөл.
7	Барилгын инженерийн дэд бүтэц /Engineering infrastructure/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээвэр, харилцаа холбооны шугам сүлжээг хамруулна.
8	Барилгын абстракт нэгж /Abstract building unit/	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын нэгж талбарын үндсэн шинжүүдийг бүлэглэх орон зайн объектын төрөл. Олон чиг үүрэгтэй барилгын шинж чанарын өгөгдлүүд (BuildingUnit) холимог ашиглалттай/олон төрлийн үйл ажиллагаа явуулж өөр хэсэг талбай эзэлж байгаа жишээ. Орон сууц үйлчилгээний зориулалттай, бие даасан, тусад нь зарах, түрээслэх, өвлүүлэх боломжтой, гаднаас эсвэл нийтийн хэсгээс (өөр барилгын нэгжээс биш) орц, гарцтай, тус тусдаа хаалгатай барилгын дэд хэсэг юм. Хэсэг тус бүрийн онцлогоор дэд хэсэг үүсгэж байж бүртгэнэ.
9	Эрчим хүчний зарцуулалт /Energy performance/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Барилга эсвэл барилгын нэгжийн эрчим хүчний зарцуулалтыг тодорхойлох өгөгдлийн төрөл.
10	Барилгын одоогийн зориулалт /Current use/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Одоогийн ашиглалтын байдлыг нарийвчлан харуулдаг өгөгдлийн төрөл.
11	Абстракт байгууламж /Abstract other construction/	«биет төрөл» «feature type»	Полигон	Байгууламжийн үндсэн, шинж чанарын мэдээллийг бүртгэх абстракт орон зайн биет төрөл. Энэ нь “Барилга” суурь орон зайн өгөгдлийн санд харьяалагддаг ч барилга биш бие даасан байгууламж юм.
12	Суурилуулсан төхөөрөмж /Abstract installation/	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун, полигон	Барилгын үндсэн бүтээцэд бэхлэгдэх хэсэг болон инженерийн хийцтэй тоног төхөөрөмжийн үндсэн шинж

				чанаруудыг бүлэглэх орон зайн объектын төрөл. Барилга болон давхрын тоо нь янз бүр барилгын гадна талд суурилуулдаг жижиг хэмжээтэй байгууламж болон төхөөрөмж (тагт, барилгын аваарын шат, барилгын дээр байрлуулсан салхин сэнс, агааржуулалтын хоолой, барилгын дээр байрлуулсан холбоо, мэдээллийн антен,, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам нарны хавтан, өргөгч лифт, нуман хаалга, барилгатай залгаа усан халаалтай уурын зуухны яндан зэрэг).
13	Барилгын 2 хэмжээс геометр <i>/Building geometry 2D/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Барилгын геометр болон байрлал, өндрийн мэдээллийг агуулдаг өгөгдлийн төрөл.
14	Барилгын үйл ажиллагааны хугацаа <i>/Date of event/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Барилгатай холбоотой барьж эхэлсэн болон дууссан, нураасан, засварласан зэрэг үйл явдал эхэлсэн дууссан хугацааг заадаг өгөгдлийн төрөл.
15	Баримт бичиг <i>/Document/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Баримт бичгийн эх сурвалжийн хаяг, баримтыг ашиглахад шаардлагатай гэж үзсэн мета өгөгдлийн элемент.
16	Өндөр <i>/Elevation/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Өндөрийн утга болон тус өндөржилтийг хэрхэн хэмжсэн мэдээллийг агуулсан өгөгдлийн төрөл.
17	Газрын гадаргаас дээших өндөр <i>/Height above ground/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Барилгын өндрийг хэмжсэн эсвэл зураг төслөөр өгөгдсөн хэмжээ /хамгийн нам давхрын газрын гадаргаас дээших өндөр, дээврийн ирмэг хүртэлх өндөр/ (босоо тэнхлэгийн дагуух өндөр).
18	Албан ёсны үнэ <i>/Official value/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Албан ёсны утга болон түүнд хамаарах мета өгөгдлийн тухай мэдээллийг бүлэглэх өгөгдлийн төрөл..
19	Барилгын талбай <i>/Official area/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Барилга, барилгын хэсэг эсвэл барилгын нэгжийн талбайн ангиллыг агуулсан өгөгдөл төрөл.

20	Гадаад лавлагаа /External reference/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Орон зайн объектоо холбоотой аливаа мэдээллийг агуулсан бусад мэдээллийн систем.
21	Барилга ашиглалтын нөхцөл байдлын ангилал /Condition of construction value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилга ямар нөхцөлд байгааг тодорхойлно. Жишээлбэл: нураасан, ашиглахаа больсон, баригдаж байгаа, ашиглаж байгаа гэх мэт.
22	Барилгын одоогийн зориулалтын үндсэн ангилал /Current use class value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Тухайн барилга одоо ямар зориулалттай ашиглаж байгааг үндсэн ангиллаас сонгоно.
23	Барилгын одоогийн зориулалтын дэд ангилал /Current use subclass value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Тухайн барилга одоо ямар зориулалттай байгааг дэд ангиллаас сонгоно.
24	Барилгын анхны зориулалтын үндсэн ангилал /Building nature class value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилга анх баригдахдаа ямар зориулалттай баригдсаныг үндсэн ангиллаас сонгоно.
25	Барилгын анхны зориулалтын дэд ангилал /Building nature subclass value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилга анх баригдахдаа ямар зориулалттай баригдсаныг дэд ангиллаас сонгоно.
26	Байгууламжийн төрлийн ангилал /Other construction nature value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Бусад байгууламжийн төрлүүдийн ангиллын кодын жагсаалт.
27	Суурилуулсан төхөөрөмжийн ангилал /Installation nature value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилгын үндсэн бүтээцэд бэхлэгдэх хэсэг болон инженерийн хийцтэй тоног төхөөрөмжийн төрлүүдийн ангиллын кодын жагсаалт.
28	Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал /Construction infrastructure type value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилга байгууламжийн бүтээц, технологи, эзлэхүүн төлөвлөлт, инженерийн шийдэл, хийцийн төрлөөс хамаарч зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх төлөв байдлыг хэлнэ.
29	Барилгын бүтээцийн материалын ангилал /Material of structure value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилгын бүтцийн материалын ангиллын кодын жагсаалт
30	Дээврийн төрлийн ангилал /Roof type value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Дээврийн төрлийн кодын жагсаалт.

31	Галд тэсвэрлэлт зэргийн ангилал /Fire resistance value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Галд тэсвэрлэлтийн зэрэг
32	Халаалтын эх үүсвэрийн ангилал /Heating source value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилга, барилгын хэсэг эсвэл барилгын нэгжийн халаалтын эх үүсвэрийн ангилал.
33	Халаалтын системийн ангилал /Heating system value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилга, барилгын хэсэг эсвэл барилгын нэгжийн халаалтын системийн ангилал.
34	Усан хангамжийн эх үүсвэрийн ангилал /Water source value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Усан хангамжийн эх үүсвэрийн ангиллын кодын жагсаалт.
35	Цахилгаан хангамжийн эх үүсвэрийн ангилал /Electrical source value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Цахилгаан хангамжийн эх үүсвэрийн ангиллын кодын жагсаалт.
36	Ариутгах татуургын системийн ангилал /Sewer system value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Ариутгах татуургын системийн ангиллын кодын жагсаалт.
37	Холбоо дохиоллын системийн ангилал /Communication alarm system value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Холбоо дохиоллын системийн кодын жагсаалт
38	Галын дохиоллын системийн ангилал /Fire alarm system value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Галын дохиоллын системийн кодын жагсаалт
39	Эрчим хүчний зарцуулалтын ангилал /Energy performance value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилга, барилгын хэсэг эсвэл барилгын нэгжийн эрчим хүчний зарцуулалтын ангилал.
40	Өмчийн хэлбэрийн ангилал /Property type value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Тухайн барилгыг захиран зарцуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд, төрийн эрх бүхий байгууллага.
41	Барилгын байрлалын утгын ангилал /Horizontal geometry reference value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилгын орон зайн байрлалын утгын ангиллын кодын жагсаалт.
42	Баримт бичгийн эх үүсвэрийн ангилал /Source status value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилгын баримт бичиг нь албан ёсны эсэхийг тодорхойлох кодын жагсаалт.

43	Барилгын өндрийн цэгийн ангилал <i>/Elevation reference value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилгын булангийн цэгүүдийн өндөр, угсралтын түвшний өндрүүд, дээврийн дээд түвшин, хамгийн өндөр, нам цэгүүд гэх мэт
44	Өндрийг тооцсон аргын ангилал <i>/Height status value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газрын гадаргаас дээших өндрийг хэмжсэн байрлал болон элементүүдийн жагсаалт. Барилгын булангийн цэгүүдийн өндөр, угсралтын түвшний өндрүүд, дээврийн дээд түвшин, хамгийн өндөр, нам цэгүүд гэх мэт
45	Албан ёсны үнийн ангилал <i>/Official value reference value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилга, барилгын хэсэг эсвэл барилгын нэгжийн албан ёсны үнийн ангилал.
46	Мөнгөн тэмдэгтийн ангилал <i>/Currency value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Мөнгөн тэмдэгтийн ангиллын кодын жагсаалт.
47	Барилгын талбайн ангилал <i>/Official area reference value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилгын хэмжээг м2, м3, өндөр гэсэн үзүүлэлтээр илэрхийлэх. Барилгын талбайн ангиллыг илэрхийлэх кодын жагсаалт (албан ёсны норм, дүрмийг баримтална).

А.1.2 Өгөгдлийн багц: 2 хэмжээст барилга (Buildings 2D)

Д/д	Өгөгдлийн нэр	Сtereo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Барилга <i>/Building/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун, полигон	Барилга гэдэг нь хүн, амьтан амьдрах болон эд зүйл байрлуулах, эсвэл үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэргээр ашиглах зориулалттай газар дээрх болон газар доорх битүү байгууламж юм.
2	Барилгын хэсэг <i>/Building part/</i>	«биет төрөл» «feature type»	полигон	Барилгын нэмэлт хэсэг.
3	Барилгын нэгж <i>/Building unit/</i>	«биет төрөл» «feature type»	полигон	Барилгын нэгж нь (BuildingUnit) хуваагдашгүй, бие даасан, тусад нь зарах, түрээслэх, өвлүүлэх боломжтой, гаднаас эсвэл нийтийн хэсгээс (өөр барилгын нэгжээс биш) өөрийн тусгаарлагдах хэсэгтэй барилгын дэд хэсэг юм.

4	Суурилуулсан төхөөрөмж <i>/Installation/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун, полигон	Барилгын үндсэн бүтээцэд бэхлэгдэх хэсэг болон инженерийн хийцтэй тоног төхөөрөмжийн үндсэн шинж чанаруудыг бүлэглэх орон зайн объектын төрөл. Барилга болон давхрын тоо нь янз бүр барилгын гадна талд суурилуулдаг жижиг хэмжээтэй байгууламж болон төхөөрөмж (тагт, барилгын аваарын шат, барилгын дээр байрлуулсан салхин сэнс, агааржуулалтын хоолой, барилгын дээр байрлуулсан холбоо, мэдээллийн антен,, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам нарны хавтан, өргөгч лифт, нуман хаалга, барилгатай залгаа усан халаалтай уурын зуухны яндан зэрэг).
5	Байгууламж <i>/Other construction/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун, полигон	Байгууламж нь үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт, түнэл, салхин сэнс, түүхийн барилга байгууламж, хөшөө дурсгал зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээ. “Барилга” суурь орон зайн өгөгдлийн санд харьяалагддаг ч барилга биш бие даасан байгууламж юм.

А.1.3 Өгөгдлийн багц: 3 хэмжээст барилга (Buildings 3D)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Барилга <i>/Building/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун, полигон	Барилга гэдэг нь хүн, амьтан, эд зүйл байрлуулах, эсвэл бараа үйлдвэрлэх зориулалтаар ашиглах зориулалттай газар дээрх эсвэл газар доорх битүү байгууламж юм.
2	Барилгын хэсэг <i>/Building part/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын нэмэлт хэсэг.
3	Барилгын нэгж <i>/Building unit/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын нэгж нь (BuildingUnit) хуваагдашгүй, бие даасан, тусад нь зарах, түрээслэх, өвлүүлэх боломжтой, гаднаас эсвэл нийтийн хэсгээс (өөр барилгын нэгжээс биш) өөрийн тусгаарлагдах хэсэгтэй барилгын дэд хэсэг юм.

4	Суурилуулсан төхөөрөмж <i>/Installation/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун, полигон	Барилгын үндсэн бүтээцэд бэхлэгдэх хэсэг болон инженерийн хийцтэй тоног төхөөрөмжийн үндсэн шинж чанаруудыг бүлэглэх орон зайн объектын төрөл. Барилга болон давхрын тоо нь янз бүр барилгын гадна талд суурилуулдаг жижиг хэмжээтэй байгууламж болон төхөөрөмж (тагт, барилгын аваарын шат, барилгын дээр байрлуулсан салхин сэнс, агааржуулалтын хоолой, барилгын дээр байрлуулсан холбоо, мэдээллийн антен,, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам нарны хавтан, өргөгч лифт, нуман хаалга, барилгатай залгаа усан халаалтай уурын зуухны яндан зэрэг).
5	Байгууламж <i>/Other construction/</i>	«биет төрөл» «feature type»	Цэг, шулуун, полигон	Байгууламж нь үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт, түнэл, салхин сэнс, түүхийн барилга байгууламж, хөшөө дурсгал зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээ. “Барилга” суурь орон зайн өгөгдлийн санд харьяалагддаг ч барилга биш бие даасан байгууламж юм.
6	Хажуугийн гадаргуу <i>/Boundary surface/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын гадна бүтээцийн хэсэг (барилгын гадна тал: хана, дээвэр гэх мэт).
7	Хаалтын гадаргуу <i>/Closure surface/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Хана болон том хаалганы үүрэг гүйцэтгэдэг гадаргуу. Хаалтын гадаргууг бүрэн хаалттай барилгад ашигладаг жишээ нь онгоцны ангар, томоор онгойгддог хаалга, гараж.
8	Газрын гадаргуу <i>/Ground surface/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилга эсвэл барилгын хэсгийн газрын гадаргуу дээр байрлах орон зайн объект.
9	Ханын гадаргуу <i>/Wall surface/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын гадна фасад.

10	Фасадын материалын ангилал <i>/Material of facade value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Фасадын материалын ангиллын кодын жагсаалт.
11	Консоль <i>/Outer floor surface/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Консольтой барилга. Барилгын үндсэн давхраас дээш барилгын үндсэн гадна ханаас илүү гарсан хэсэг.
12	Дээврийн гадаргуу <i>/Roof surface/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын дээврийн хэлбэр дүрс, шинж чанарыг заагладаг гадаргуу.
13	Шал <i>/Floor Surface/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Шалны шинж чанарыг заагладаг гадаргуу.
14	Хөндлөн даацын элемент <i>/Outer ceiling surface/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын гадна ханын дотогш түрж орсон хэсгийн тааз.
15	Нээгддэг биет <i>/Opening/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Дотор болон гадна ханын хаалга, цонх (нээж хаадаг) гэх мэт суурь ангиллын биетийн төрөл (Opening). Хаалга, цонх зэрэг нээгддэг биет нь зөвхөн LoD3 эсвэл LoD4 загваруудад орно.
16	Хаалга <i>/Door/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын гаднах хаалга, өрөөнүүдийн хаалганууд.
17	Хаалганы төрөл <i>/Type of door/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хаалганы төрлийн кодын жагсаалт
18	Цонх <i>/Window/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Байшин барилгад гэрэл, агаар оруулах хэсэг.
19	Цонхны төрөл <i>/Type of window/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Цонхны төрлийн кодын жагсаалт.
20	Өрөө <i>/Room/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Өрөө гэдэг нь ханаар тусгаарлагдсан барилгын нэг хэсэг юм.
21	Өрөөний зориулалтын ангилал <i>/Room nature value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Өрөөний зориулалт болон хэрэглээгээр ангилах.

22	Дотор суурилуулсан төхөөрөмж <i>/Interior installation/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилга болон барилгын хэсгүүдийн дотор талд суурилуулдаг барилгын бүрдэл болон тоног төхөөрөмж (дотор талын шат, дотор лифт).
23	Дотор суурилуулсан төхөөрөмжийн ангилал <i>/Internal installation nature value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Барилга болон барилгын хэсгүүдийн дотор талд суурилуулдаг барилгын бүрдэл болон тоног төхөөрөмж түүний ангилал (дотор талын шат, дотор лифт).
24	Тодорхойлсон бүтэц <i>/Parameterized texture/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Барилгын гадна тал буюу фасадын төрх байдлыг дүрсэлсэн хийц.
25	Барилгын 3 хэмжээст геометр <i>/LoD/ /Building geometry 3D Lod/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Барилгын 3 хэмжээст геометр, эсвэл барилгын хэсэг болон мета өгөгдлийн мэдээллийг бүлэглэх өгөгдлийн төрөл.
26	Барилгын 3 хэмжээст геометр <i>/LoD1/ /Building geometry 3D Lod1/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	LoD1-ээр төлөөлүүлж 3 хэмжээст геометрийн өгөгдлийг бүлэглэх өгөгдлийн төрөл.
27	Барилгын 3 хэмжээст геометр <i>/LoD2/ /Building geometry 3D Lod2/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	LoD2-оор төлөөлүүлж 3 хэмжээст геометрийн өгөгдлийг бүлэглэх өгөгдлийн төрөл.
28	Хажуугийн 3 хэмжээст геометр <i>/Boundary geometry 3D/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Өөр өөр гадаргын төвшний хил зааг дээрх 3D хэмжээстийн өгөгдлийн мэдээлэл. (хананы гадаргуу, дээврийн гадаргуу, хаалтын гадаргуу, газрын гадаргуу, гаднах тааз гадаргуу, гаднах шалны гадаргуу)
29	3 хэмжээст гадаргуу дээр байрлуулах арга <i>/Text coord gen/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Солбицлын хоёр тогтолцооны хоорондын шилжүүлэлтийг ашиглан барилгын (3D орон зайн) зургийн файлыг (2D хавтгайн тэгш өнцгийн солбицол) байрлуулах арга.
30	Барилгын гадаргуу дээр байрлуулах арга <i>/Text coord list/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Зургийн солбицлыг барилгын харгалзах бүтээцийн солбицлуудтай холбож, барилгын гадаргуу дээр зургийн файлыг байрлуулах арга.
31	Барилгын гадаргуу болон 3 хэмжээст гадаргуу дээр байрлуулах арга	«өгөгдөл төрөл» «data type»	-	Text Coord List болон Text Coord Gen хувиргалтыг зэрэг ашигладаг хувилбар.

	<i>/Texture parametrization/</i>			
32	Дүрслэлийн төрөл <i>/Mime type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Дүрслэлийн төрөл.
33	Хийцийн төрөл <i>/Texture type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хийцийн зориулалтаар ангилсан төрөл.

А. 2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн давхаргын атрибутын агуулга

А.2.1 Өгөгдлийн багц - Барилгын суурь өгөгдөл (Buildings base)

А.2.1.1 Биет төрлийн нэр: Абстракт барилга байгууламж (Abstract construction)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Дотоод танигч /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
2	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
3	Танигчийн хувилбар /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
4	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	20	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
5	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	20	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
6	Барилга ашиглалтын нөхцөл байдал /Condition of construction/	Барилгын ашиглалтын нөхцөл байдлын ангилал /Condition of construction value/	-	-	Condition of construction value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.

7	Барилга барьсан хугацаа /Date of construction/	«Барилгын үйл ажиллагааны хугацаа» «Date of event»	-	-	Барилга барих, эсхүл хуучин барилга байгууламжийг буулгаж барьсан огноо.
8	Барилга өргөтгөх, шинэчлэх, засварласан хугацаа /Date of renovation/	«Барилгын үйл ажиллагааны хугацаа» «Date of event»	-	-	Ашиглалтын хэвийн нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн засварлаж, нэмэлт болон тусгай тоног төхөөрөмж суурилуулсан огноо.
9	Барилга нураасан хугацаа /Date of demolition/	«Барилгын үйл ажиллагааны хугацаа» «Date of event»	-	-	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг ноцтой зөрчиж баригдсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон барилга байгууламжийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буулгасан огноо.
10	Өндөр /Elevation/	«Өндөр» «Elevation»	-	-	Далайн түвшний гадаргаас тухайн цэг хүртэлх эгц босоо зай.
11	Гадаад лавлагаа /External reference/	«Гадаад лавлагаа» «External reference»	-	-	Орон зайн объектой холбоотой аливаа мэдээллийг агуулсан бусад мэдээллийн системийн эх сурвалж, эшлэл.
12	Газрын гадаргаас дээших өндөр /Height above ground/	«Газрын гадаргаас дээших өндөр» «Height above ground»	-	-	Барилгын өндрийг хэмжсэн эсвэл зураг төслөөр өгөгдсөн хэмжээ /хамгийн нам давхрын газрын гадаргаас дээших өндөр, дээврийн ирмэг хүртэлх өндөр/ (босоо тэнхлэгийн дагуух өндөр).
13	Барилга байгууламжийн нэр /Name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Барилга байгууламжийн нэр. Газар зүйн нэрийн өгөгдлийн дэд сангаас авна.

A.2.1.2 Биет төрлийн нэр: Абстракт барилга (Abstract building)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Дотоод танигч /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.

2	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
3	Танигчийн хувилбар /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
4	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	20	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
5	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	20	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
6	Барилгын анхны зориулалтын үндсэн ангилал /Building nature class type/	Барилгын анхны зориулалтын үндсэн ангилал /Building nature class value/	-	-	Барилгын зориулалтаас хамаарсан төрөл. Building nature class value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
7	Барилгын анхны зориулалтын дэд ангилал /Building nature subclass type/	Барилгын анхны зориулалтын дэд ангилал /Building nature subclass value/	-	-	Барилгын зориулалтаас хамаарсан төрөл. Building nature subclass value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
8	Барилгын одоогийн зориулалт /Current use/	«Барилгын одоогийн зориулалт» «Current use»	-	-	Барилгын үйл ажиллагаа, одоогийн ашиглалтын зориулалт. Уг атрибурад ямар нэгэн үйл ажиллагаа зохион байгуулагддаг барилгыг голчлон оруулна.
9	Барилга ашиглалтын нөхцөл байдал /Condition of construction/	Барилгын ашиглалтын нөхцөл байдлын ангилал /Condition of construction value/	-	-	Condition of construction value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
10	Барилга барьсан хугацаа /Date of construction/	«Барилгын үйл ажиллагааны хугацаа»	-	-	Барилга барих, эсхүл хуучин барилга байгууламжийг буулгаж барьсан огноо.

		«Date of event»			
11	Барилга өргөтгөх, шинэчлэх, засварласан хугацаа /Date of renovation/	«Барилгын үйл ажиллагааны хугацаа» «Date of event»	-	-	Ашиглалтын хэвийн нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн засварлаж, нэмэлт болон тусгай тоног төхөөрөмж суурилуулсан огноо.
12	Барилга нураасан хугацаа /Date of demolition/	«Барилгын үйл ажиллагааны хугацаа» «Date of event»	-	-	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг ноцтой зөрчиж баригдсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон барилга байгууламжийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буулгасан огноо.
13	Өндөр /Elevation/	«Өндөр» «Elevation»	-	-	Далайн түвшний гадаргаас тухайн цэг хүртэлх эгц босоо зай.
14	Гадаад лавлагаа /External reference/	«Гадаад лавлагаа» «External reference»	-	-	Орон зайн объектой холбоотой аливаа мэдээллийг агуулсан бусад мэдээллийн системийн эх сурвалж, эшлэл.
15	Сууцны тоо /Number of dwellings/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	5	Тухайн давхар дахь сууцны тоо.
16	Нийт давхрын тоо /Number of floors above ground/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	5	Газрын гадаргаас дээших давхрын тоо.
17	Газрын гадаргаас дээших өндөр /Height above ground/	«Газрын гадаргаас дээших өндөр» «Height above ground»	-	-	Барилгын өндрийг хэмжсэн эсвэл зураг төслөөр өгөгдсөн хэмжээ /хамгийн нам давхрын газрын гадаргаас дээших өндөр, дээврийн ирмэг хүртэлх өндөр/ (босоо тэнхлэгийн дагуух өндөр).
18	Барилга байгууламжийн нэр /Name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Барилга байгууламжийн нэр.
	Давхрын хязгаар /Floor range/	«Давхрын хязгаар» «Floor range»			Давхрын хязгаарыг хамгийн доод ба хамгийн дээд давхраар нь тодорхойлох.

	Зоорины давхрын тоо /Number of floors below ground/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Барилгын цоколын давхрын тоо.
	Дээврийн төрөл /Roof type/	Дээврийн төрлийн ангилал /Roof type value/	-	-	Roof type value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
	Барилгын бүтээцийн материал /Material of structure/	Барилгын бүтээцийн материалын ангилал /Material of structure value/	-	-	Material of structure value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
	Галд тэсвэрлэлтийн зэрэг /Fire resistance/	Галд тэсвэрлэлтийн зэргийн ангилал /Fire resistance value/	-	-	Fire resistance value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
	Барилга байгууламжийн төвөгшил /Construction infrastructure type/	Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал /Construction infrastructure type value/	-	-	Барилга байгууламжийн бүтээц, технологи, эзлэхүүн төлөвлөлт, инженерийн шийдэл, хийцийн төрлөөс хамаарч зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх төлөв байдлыг хэлнэ. Construction infrastructure type value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.

А.2.1.3 Биет төрлийн нэр: Барилга (Building)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Дотоод танигч /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
2	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
3	Танигчийн хувилбар /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг

					илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
4	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	20	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
5	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	20	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
6	Барилгын анхны зориулалтын үндсэн ангилал /Building nature class type/	Барилгын анхны зориулалтын үндсэн ангилал /Building nature class value/	-	-	Барилгын зориулалтаас хамаарсан төрөл. Building nature class value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
7	Барилгын анхны зориулалтын дэд ангилал /Building nature subclass type/	Барилгын анхны зориулалтын дэд ангилал /Building nature subclass value/	-	-	Барилгын зориулалтаас хамаарсан төрөл. Building nature subclass value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
8	Барилгын одоогийн зориулалт /Current use/	«Барилгын одоогийн зориулалт» «Current use»	-	-	Барилгын үйл ажиллагаа, одоогийн ашиглалтын зориулалт. Уг атрибутада ямар нэгэн үйл ажиллагаа зохион байгуулагддаг барилгыг голчлон оруулна.
9	Газрын гадаргаас дээших өндөр /Height above ground/	«Газрын гадаргаас дээших өндөр» «Height above ground»	-	-	Барилгын өндрийг хэмжсэн эсвэл зураг төслөөр өгөгдсөн хэмжээ /хамгийн нам давхрын газрын гадаргаас дээших өндөр, дээврийн ирмэг хүртэлх өндөр/ (босоо тэнхлэгийн дагуух өндөр).
10	Давхрын хязгаар /Floor range/	«Давхрын хязгаар» «Floor range»			Давхрын хязгаарыг хамгийн доод ба хамгийн дээд давхраар нь тодорхойлох.
11	Сууцны тоо /Number of dwellings/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Тухайн давхар дахь сууцны тоо.
12	Нийт давхрын тоо /Number of floors above ground/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Газрын гадаргаас дээших давхрын тоо.

13	Зоорины давхрын тоо /Number of floors below ground/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Барилгын цоколын давхрын тоо.
14	Барилга ашиглалтын нөхцөл байдал /Condition of construction/	Барилгын ашиглалтын нөхцөл байдлын ангилал /Condition of construction value/	-	-	Condition of construction value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
15	Дээврийн төрөл /Roof type/	Дээврийн төрлийн ангилал /Roof type value/	-	-	Roof type value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
16	Барилгын бүтээцийн материал /Material of structure/	Барилгын бүтээцийн материалын ангилал /Material of structure value/	-	-	Material of structure value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
17	Галд тэсвэрлэлтийн зэрэг /Fire resistance/	Галд тэсвэрлэлтийн зэргийн ангилал /Fire resistance value/	-	-	Fire resistance value кодын жагсаалтын ангиллын утгаас авна.
18	Газар хөдлөлийн тооцоот балл /Calculated seismic score/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	20	Газар хөдлөлтөд тэсвэртэй баллын хэмжээ.
19	Барилга барьсан хугацаа /Date of construction/	«Барилгын үйл ажиллагааны хугацаа» «Date of event»	-	-	Барилга барих, эсхүл хуучин барилга байгууламжийг буулгаж барьсан огноо.
20	Барилга өргөтгөх, шинэчлэх, засварласан хугацаа /Date of renovation/	«Барилгын үйл ажиллагааны хугацаа» «Date of event»	-	-	Ашиглалтын хэвийн нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн засварлаж, нэмэлт болон тусгай тоног төхөөрөмж суурилуулсан огноо.
21	Барилга нураасан хугацаа /Date of demolition/	«Барилгын үйл ажиллагааны хугацаа» «Date of event»	-	-	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг ноцтой зөрчиж баригдсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон барилга

					байгууламжийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буулгасан огноо.
22	Өндөр /Elevation/	«Өндөр» «Elevation»	-	-	Далайн түвшний гадаргаас тухайн цэг хүртэлх эгц босоо зай.
23	Гадаад лавлагаа /External reference/	«Гадаад лавлагаа» «External reference»	-	-	Орон зайн объектоо холбоотой аливаа мэдээллийг агуулсан бусад мэдээллийн системийн эх сурвалж, эшлэл.
24	Барилга байгууламжийн нэр /Name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Барилга байгууламжийн нэр. Газар зүйн нэрийн өгөгдлийн дэд сангаас авна.
